



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.8 дахь заалт, 19.4 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ НЬ:

1.Газрын тосны тухай хууль тогтоомж, бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн талаар иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн өргөдлийн дагуу хяналт шалгалт хийж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

О.Баасанхүү -Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга

Гишүүд:

Ж.Батзандан -Улсын Их Хурлын гишүүн
Д.Сарангэрэл -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Дэд хэсгийн ахлагч:

О.Эрдэнэбат -Өргөдлийн байнгын хорооны Ажлын албаны референт

Гишүүд:

Ж.Лхамрагчаа -Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт үнэлгээний хэлтсийн референт

Э.Амарбат -Авилгатай тэмцэх газрын, Мөрдөн байцаах албаны дарга

С.Магнайсүрэн -Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Ч.Жамсран -Газрын тосны газрын Ашиглалт, олборлолтын хэлтсийн дарга

Б.Бямбацогт -Газрын тосны газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Ж.Энхбат


-Авто тээврийн үндэсний төв, Тээвэр
зохицуулалтын газрын дарга

С.Баяраа

-Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын улсын
ахлах байцаагч

3.Тогтоолын дагуу хяналт, шалгалтын дүнг гаргаж, 2015 оны 6 сард багтаан
Байнгын хороонд танилцуулахыг ажлын хэсэг /О.Баасанхүү/-т даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



О.БААСАНХҮҮ